



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас/факс: (976-11) 329084  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2013. 12. 31 № 114863  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

*Б.Гарамгайбаатар*  
2014.01.07

Тогтоолын хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлаас 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлснээр манай улсын үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болох, томоохон компаниуд хувьцаагаа гаргах, давхар бүртгүүлэн арилжих, ингэснээр урт хугацаат хөрөнгө оруулалтын эх үүсвэр татах таатай боломжтой болсон юм. Улсын Их Хурлаас Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 41 дүгээр тогтоол /цаашид “тогтоол” гэх/-ыг баталсан бөгөөд энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх үүргийг Засгийн газар болон Санхүүгийн зохицуулах хороонд өгсөн билээ. Дээрх тогтоолыг бүхэлд нь хэрэгжүүлэхэд Засгийн газар, түүний яам, агентлагуудын оролцоо чухал байгаа бөгөөд тус Хороо дангаараа гүйцэтгэх боломжгүй ажлууд байгааг энд дурдах нь зүйтэй болов уу. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр хийж, гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг үүгээр хүргүүлж байна.

**Нэг.** Тогтоолын 1-д “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай сургалт, сурталчилгааг тодорхой хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог нарийвчлан гаргаж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх” гэж заасан. Тус Хорооны зүгээс өөрийн санхүүгийн эх үүсвэр болон хамтран ажилладаг гадаадын болон олон улсын байгууллагын тусалцаатайгаар тодорхой хөтөлбөрийн дагуу тус хуулийн шинэ зохицуулалтын онцлог, бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх зохицуулалт зэргийн талаар үнэт цаасны зах зээлийн оролцогч мэргэжлийн байгууллага, хувьцаат компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болон зах зээлийн бусад оролцогч, сонирхогч этгээдийн хүрээнд хэд хэдэн удаагийн мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр шинэчлэн батлагдсан хуулийн талаарх мэдээллийг хүргэж ажиллаж байна.

**Хоёр.** Тогтоолын 2-д “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан дүрэм, журам, заавар, стандарт, нэр томъёоны тайлбарыг холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран 2013 онд багтаан боловсруулж, батлах” үүргийг тус Хороонд даалгасан. Дээрх хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг тус Хорооноос батлан мөрдүүлэхээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хэд хэдэн журмыг боловсруулан батлаад байгаа бол бусад төрийн байгууллагатай хамтран батлах журмын төслүүдийг санал авч, хэлэлцэж, батлахаар ажиллаж байна. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны бүртгэл болон давхар бүртгэлийн журам” /ПО/, “Үнэт цаасны зах зээл дээрх зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн журам”, “Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн журам”, “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам”, “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх журам”, “Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам”, “Дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны” зэрэг

006016

журмууд батлаад байна. Харин “Кастодианы үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн тухай журам”-ыг Монголбанктай хамтран батлах бөгөөд уг журмын төслийг тус Хорооноос боловсруулан Монголбанкинд хүргүүлээд байна. Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зах зээлийн шинэ нэр томъёо, ойлголтууд ихээр зохицуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн болон төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран, тэдгээрийг тайлбарласан “Хөрөнгийн зах зээлийн нэр томъёоны тайлбар толь 2013”-ыг боловсруулан хэвлүүлээд байгаа бөгөөд энэхүү толь нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, санхүүгийн компаниуд болон бусад уг зах зээлийг сонирхсон хэн бүхний хувьд сонирхон үзэх, шимтэн судлах гарын авалга болоод зогсохгүй цаашид хөрөнгийн зах зээл дэх шинэ ойлголт, нэр томъёог жигдлэх, хэвшүүлэхэд онцгой ач холбогдолтой байх юм.

**Гурав.** Тогтоолын 3-д “хөрөнгийн биржийн бүртгэлийн шалгуур хангахгүй байгаа хувьцаат компанийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах, татан буугдсан хамтын сан болон хөрөнгө оруулалтын сангийн үлдэгдэл хөрөнгийн асуудлыг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн хэлбэрээр шийдвэрлэх” үүргийг тус Хорооны зүгээс хэрэгжүүлэх ажлыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолоор хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлдэггүй, үйл ажиллагаа нь явагддаггүй, хувьцаа нь арилжаалагддаггүй, өмч хөрөнгөгүй болсон нийт 165 хувьцаат компанийн Хөрөнгийн бирж дээрх арилжааг зогсоож, улмаар түүнээс хойш тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсээр ирсэн байна. Тус Хорооноос 2008-2012 онуудад дээрх арилжаа нь зогссон компаниудаас 50 ХК-ийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасч шийдвэрлэсэн байдаг. Харин Улсын Их Хурлын дээрх тогтоол батлагдсанаас хойш тус Хорооны 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 233 дугаар тогтоолоор нэр бүхий 5 хувьцаат компанийг, Хорооны 2013 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 278 дугаар тогтоолоор нэр бүхий 57 хувьцаат компанийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасаад байна. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын дээрх тогтоол батлагдсанаас хойш нийтдээ 74 хувьцаат компанийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасаад байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдсан, компанийн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр бүртгүүлсэн, шүүх болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буугдсан нийт 13 хувьцаат компанийг үнэт цаасны бүртгэлээс хасахаар судалгаа, мэдээллийг нэгтгэж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Харин арилжааг нь зогсоосон дээрх 165 хувьцаат компаниас үлдээд буй 36 орчим хувьцаат компанийн удирдлагад тус Хорооноос хувьцааны арилжааг сэргээх, нэмэлт хувьцаа гаргах, хэлбэрээ өөрчлөх, эсхүл татан буугдах зэрэг хэлбэрийн аль нэгийг сонгон асуудлаа шийдвэрлэх хугацаатай үүргийг өгөөд байна. Ингэснээр Хөрөнгийн бирж дээр бүртгэлийн шаардлага хангахуйц цөөн, томоохон компаниуд үлдэх юм. Хороо дээрх компаниудыг бүртгэлээс хасахдаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ямагт тэргүүнд тавьж, тэдгээрийн эрх ашгийг хохироохгүй байх хэлбэрийг сонгож ажиллаж байна.

**Дөрөв.** Тогтоолын 4-д “үйл ажиллагаа явуулдаггүй, хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдсан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй болон хувьцаат компанийн шаардлага хангахгүй байгаа компанийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал боловсруулж 2013 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах” ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 278 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хассан нэр бүхий 57 компанийн удирдлагууд болон эрх бүхий этгээдүүдэд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ 2013 онд багтаан Хороонд ирүүлэхийг анхааруулан, хугацаатай үүрэг өгсөн ба Хорооны цахим хуудсаар мөн олон нийтэд мэдээлсэн. Дээрх хугацаанд хүсэлт ирүүлээгүй тохиолдолд уг компаниудыг татан буулгахад шаардлагатай арга хэмжээ, тусгай зохицуулалтын саналыг Улсын Их Хуралд танилцуулахаар төлөвлөж байна.

**Тав.** Тогтоолын 5-д “хөрөнгө оруулалтын сан болон холбогдох бусад сангийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төсөл боловсруулан 2013 оны 3 дугаар улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” ажлын хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт тус Хорооноос төлөөлөл оролцон, хуулийн төслийг боловсруулж, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барисан. Улмаар Улсын Их Хурлаас Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр баталсан билээ.

**Зургаа.** Тогтоолын 6-д “хөрөнгийн зах зээлийг дэмжих бодлогын хүрээнд Засгийн газрын урт хугацаат өрийн хэрэгслийг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах арга хэмжээг зохион байгуулах” ажлын хүрээнд тус Хорооноос 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1/2650 тоотор хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай албан бичгийг Монголбанк, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Уул уурхайн яам, Төрийн өмчийн хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК зэрэг холбогдох байгууллагад хүргүүлснээр Монголбанк уг ажлын хэсэгт орж ажиллах боломжгүй гэсэн хариу өгсөн тул бусад байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсгийг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 224/230 дугаар хамтарсан тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр тус Хороо өөрийн эрх хэмжээний хүрээнд санаачлага гарган идэвхтэй ажиллаж байгаа боловч дан ганц манай байгууллагын зүтгэлээр бүрэн хийгдэх боломжгүй ажил гэдгийг энд дурдах нь зүйтэй болов уу. Учир нь Засгийн газрын үнэт цаасыг гаргах, арилжих хэлбэр зэргийг тодорхойлдог байгууллага нь Засгийн газар, түүний дотор Сангийн яам тул манай байгууллагын зүгээс шууд оролцох эрх хэмжээ хуулиар олгогдоогүй байдаг.

**Долоо.** Тогтоолын 7-д “Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдийн хувьцааг Хөрөнгийн биржээр арилжаалах” үүргийг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр хамтран ажиллах саналыг Уул уурхайн яам, Төрийн өмчийн хороонд тус тус 2013 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/271 тоотор хүргүүлсэн боловч уг ажил хийгдэхгүй өнөөг хүрээд байна. Хуулийн дээрх зохицуулалт 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад шинээр хуульчлагдсан боловч өнөөг хүртэл уг хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий байгууллагууд болох Эрдэс баялаг, эрчим хүчний яам /хуучнаар/, Уул уурхайн яам, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар болон Төрийн өмчийн хороо зэрэг холбогдох байгууллагууд руу удаа дараа хуулийн дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналыг гаргаж ажиллаж ирсэн боловч уг ажлын үр дүн хангалтгүй байна. Харин стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК-иуд нь Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байдаг бол “Эрдэнэс Тавантолгой” компани нь хувьцаагаа тус Хороонд бүртгүүлэхээр ажиллаж байгаа болно.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН